БАЯНХОНГОР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2026 оны 06 дугаар сарын 02 Бүрд

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур | Хугацаа | Хариуцах эзэн | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Нэг. Төрийн үйл ажиллагааны мэдээллийг цахимжуулах замаар иргэдийн мэдэх эрхийг хангах** | | | | | | |
| 1.1 | Өөрийн байгууллагын олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг тухай бүр цахим системд нээлттэй байршуулж, олон нийтэд сурталчлах | -олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээллийн тоо<br>-олны танил гурваас доошгүй хүмүүсээр байгууллагыг сурталчилгааг хийлгэсэн байх<br>-цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хоёроос доошгүй нөлөөллийн ажил зохион áайгуулсан байх | Жилийн турш | ҮНТ-ын Оператор | www.shilen.gov.mn болон www.bayanbulag.gov.mn олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллэх мэдээ мэдээллийг тухай бүр нь тайлагнаж дээд шатны байгууллагаар дүгнүүлж хэвшсэн. Тухайн ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2024 оны 02 дугаар сараас эхлэн Мэдээлэл технологийн ажилтан авч ажлуулж байна.<br>Байгууллагын албан ёсны пэйж /Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Засаг даргын Тамгын газар/ хуудсанд цаг үеийн болон нээлттэй мэдээллэх мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна. | 100 |
| 1.2 | Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн<br>а/ байгууллагын албан ёсны цахим хуудас | -тогтмол шинэчлэн тогтвортой байршуулсан байх,<br>-түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар салбар хариуцсан | жилийн турш | Байгууллагын эрх зүйн хөтөч нар | Авлигатай тэмцэх газар болон аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэсийн албан ёсны цахим хуудаст байршуулсан авлигатай тэмцэх сургалт нөлөөллийн арга хэмжээ, богино хэмжээний шторк зэргийг ЗДТГ-ын албан ёсны пэйж хуудсанд барйшуулан иргэдэд мэдээлэл хүргэсэн. Мөн сумын албан ёсны цахим сайт www.bayanbulag.gov.mn -д байршуулж хэвшсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | б/сошиал сувгууд в/ дотоод сүлжээ г/ хэвлэл мэдээллийн хэрэгсэл д/ мэдээлэл сурталчилгааны самбар лед дэлгэц е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх | ажилтанд тухай бүрт нь тайлагнадаг байх, -харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших, -тайланд холбогдох нотломжийг хавсаргаж хэвших | | | | |
| 1.3 | Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших | -Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж тайлагнах, -Хуулийн хүрээнд шуурхай бодитой шийдвэрлэж хэвших -Иргэд олон нийтээс байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал, чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээлэлд дүн, | жилийн турш | Тамгын газрын дарга | Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж зөрчлийг арилгуулсан. Тухайн байгууллагын албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Авлигын эсрэг үйл ажиллагааны талаар сургалт мэдээлэл хийсэн. | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх Тайланд нотломжийг хавсаргасан байх -Ирүүлсэн гомдолд хийсэн дүн шинжилгээний үр дүнд суурилсан эерэг нөлөөллийн арга хэмжээг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байх | | | | |
| **Хоёр. Шударга байдлын үнэлгээг сайжруулах** | | | | | | |
| 2.1 | Сум, байгууллагын албан хаагчдыг авлигад өртөх эрсдэлийг бууруулах нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх | -Эрсдэлтэй албан хаагчдаар баталгааг гаргасан байх -Авлигын чиглэлээр хүргүүлсэн албан бичиг зөвлөмж, чиглэлийн хэрэгжилтийг хангаж ажилласан байх -Бүх албан хаагчдыг сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамруулсан байх | Жилийн турш | Тамгын газрын дарга<br><br>Хууль эрх зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн<br><br>Байгууллагын Эрх зүйн хөтөч нар | Төрийн байгууллагын шинээр томилогдсон албан хаагчдыг болон төрийн албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад /давтан/ цахимаар бүрэн хамруулсан.<br>байгууллагын эрх зүйн хөтөч нар өөрийн байгууллагын албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Авлигын эсрэг сургалтыг зохион байгуулсан.<br>Авлигын эсрэг үйл ажиллагааны талаарх гарын авлагыг төрийн албан хаагчид айл өрхүүдээр явахдаа болон багуудын ИНХ дээр тараасан.<br>Байгууллагын эрх зүйн хөтөч нар сургалт мэдээллийг тогтмол хийж байна. | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | -Шинэ томилогдсон албан хаагчдыг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх ёс зүйн сургалтад бүрэн хамруулсан байх, -Хууль дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийж, нэмэлт өөрчлөлт хийх санал иргүүлсэн байх -Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгасан байх | | | | |
| 2.2 | Авлигатай холбоотой мэдээлэл өгсөн иргэний мэдээллийн нууцыг хэрхэн хангах, хамгаалах талаар | -Дотоод журамд өөрчлөлт оруулсан байх -Хэрэгжилт үр дүнг тооцож ажилласан байх | Жилийн турш | Тамгын газрын дарга Хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн | Хамт олны хурлаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд Авлигатай холбоотой мэдээлэл өгсөн иргэний мэдээллийн нууцыг хангах талаар нэмэлт өөрчлөлт оруулсан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах | | | Байгууллагын Эрх зүйн хөтөч нар | | |
| 2.3 | Байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачлага гарган 1 арга хэмжээ хэрэгжүүлэх | шинээр санаачлан хийсэн ажлын тоо, үр дүнд | жилийн турш | Байгууллагын дарга нар Албан хаагчид | Багийн Иргэдийн нийтийн хурлаар Авлигын эсрэг сургалт зохион байгуулж гарын авлага тараасан. | 50 |
| **Гурав. Иргэний нийгмийн байгууллагын бодит оролцоог хангаж иргэнд ээлтэй бодлого шийдвэр гаргах нөхцөлийг хэвшүүлэх** | | | | | | |
| 3.1 | Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо хамтын ажиллагааг нэмэгдүүлэх | -Салбар бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгаа гаргасан байх,<br>-Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга | жилийн турш | Тамгын газрын дарга | Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс төрийн албан хаагчдад Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх сургалт мэдээллийг хийсэн. | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэмжээ авсан байх<br>-Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх ажлыг хувийн хэвшил, Иргэний нийгмийн байгууллагаар гүйцэтгэсэн байх,<br>-Үр дүнг тооцож тайлагнасан байх. | | | | |
| **Дөрөв. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах соён гэгээрүүлэх, үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх** | | | | | | |
| 4.1 | Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг арга хэмжээг зохион байгуулах | -Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх.<br>-Авлигатай тэмцэх газраас өрнүүлж буй аян уриалгатай уялдсан байх<br>-Үр дүнг тооцсон байх. | Жилийн турш | Төрийн байгууулагууд | 9 сард зохион байгуулахаар төлөвлөсөн. | |
| 4.2 | Өөрийн байгууллагын эрх | -Мэдээллийг Авлигатай тэмцэх | Жилийн турш | | Авлигын эсрэг сургалт зохион байгуулж гарын авлага тараасан. | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл иргэдэд тараадаг, хэвлэмэл материал зэрэг авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах шүгэл үлээхийг сурталчлан таниулсан түүнд уриалсан мэдээлэл болон авлигыг мэдээлэх 1-110 дугаарыг оруулан сурталчлах | газраас буюу баталгаат Эх сурвалжаас авсан байх<br>-Авлигатай тэмцэх Газрын авлигын мэдээлэл хүлээн авах дугаарыг төрөл бүрийн хэлбэрээр сурталчлан ажилласан байх<br>-Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх<br>- Тайланд 1-110 дугаарыг сурталчилсан холбогдох нотломжийг хавсаргаж хэвших | | Байгууллагын дарга нар | тус гарын авлага болон байгууллагын албан ёсны пэйж хуудсаар Авлигатай тэмцэх газрын авлигын мэдээлэл хүлээн авах дугаарыг төрөл бүрийн хэлбэрээр сурталчилсан.<br>https://www.facebook.com/profile.php?id=61562383937466 | |
| 4.3 | Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авилгад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх | -Авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн хоёроос доошгүй контент бүтээлгэж олон нийтэд түгээж ажилласан байх<br>-Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ /фейсбүүк, твиттер, | Жилийн турш | Байгууллагын дарга нар<br>Эрх зүйн хөтөч нар | Байгууллагын эрх зүйн хөтөч нар албан хаагчдад Авлигын эсрэг хууль, авлигын эрсдлээс ангид байх чиглэлээр сургалт мэдээлэл хийсэн.<br>Контент бүтээх болон бусад нөлөөллийн ажлуудыг 3 дугаар улиралд хийхээр төлөвлөсөн. | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | инстаграм ютүб суваг/ мөн лед дэлгэц, сурталчилгааны самбарт байршуулах зэрэг бүхий л боломжтой хэлбэрээр олон нийтэд хүргэсэн байх | | | | |
| 4.4 | Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэхэд соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн оролцоог нэмэгдүүлж, мэдээлэл солилцох сувгийг хөгжүүлэх | Авлигыг үл тэвчих үзлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд оролцсон соёл, урлаг, спорт, хэвлэл мэдээллийн салбарт хамаарах хуулийн этгээд, хувь хүний тоо | Жилийн турш | Эрх зүйн хөтөч нар | Ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллэх мэдээллийг www.shilen.gov.mn цахим санд тайлагнаж дээд шатны байгууллагаар дүгнүүлж байна. www.shilen.gov.mn, www.bayanbulag.gov.mn, https://www.facebook.com/profile.php?id=61562383937466 байгууллагын албан ёсны пэйж хуудсыг хариуцан ажиллах Мэдээлэл технологийн ажилтан 2024.02 сараас эхлэн ажлуулж байна. | 100 |
| **Тав. Төсвийн тухай хуульд төсвийн орлого, зарлагын мэдээллийг төсөв, захирагчдаар нийтлэхээс гадна эдийн болон зориулалтын ангиллаар тооцон тусгана.** | | | | | | |
| 5.1 | Төсвийн орлого зарлагын мэдээллийг эдийн засгийн болон зориулалтын дагуу харуулах тусгах | Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгааны жилийн төсвийн төслийн баримт бичгийн агуулгын үзүүлэлт | Жилийн турш | Санхүүгийн алба | Төсвийн орлого зарлагын мэдээллийг эдийн засгийн ангилал болон зориулалтын дагуу төрийн байгууллага бүр сар бүр гарган мэдээллийн самбарт байршуулж мэдээлж хэвшсэн.Шилэн дансанд төсвийн мэдээллийг байнга хугацаанд байршуулж байна.Төрийн аудит болон санхүүгийн хяналт шалгалтад жил бүр байгууллагууд санхүүгийн баримтаа хугацаанд нь шалгуулж хэвшсэн. 2025 оны төрийн аудитын шалгалтаар зөрчилгүй дүгнэлт авсан. | 100 |
| 5.2 | Төсвийн тухай хууль дахь төсвийн ерөнхийлөн | Төсвийн нээлттэй байдлын олон улсын судалгааны | жилийн турш | Санхүүгийн алба | Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагчийн мэдээллийг байгууллага тус бүр Шилэн данс болон мэдээллийн санд | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | захирагч болон төсвийн шууд захирагч гэсэн ерөнхий мэдээллийг байгууллага тус бүрээр албан тушаал нэрээр ил тодорхой болгох, нэр тус бүрээр ил тод, тодорхой мэдээлэх | жилийн төсвийн төслийн баримт бичгийн агуулгын үзүүлэлт | | | тавьж ил тод байршуулж иргэд төсвийн мэдээллийг авах бүрэн боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2026 онд хэрэгжүүлэх хөтөлбөрийн зорилт арга хэмжээний хүрээнд 8 ажил хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 868.087.4 төгрөгийн санхүүжилтийг батлуулан ажиллаж байна | |
| 5.3 | Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах | -2026 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар мэдээлэх, -Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд олон нийтийн саналыг авч холбогдох арга хэмжээг авах, -Иргэн, иргэний нийгмийн байгууллагын | Жилийн турш | Санхүүгийн алба | 2026 онд орон нутгийн хөгжлийн сангаас 327,342,100 төгрөгийн хөрөнгө оруулалт хөтөлбөр арга хэмжээ хийхээр батлагдснаас шилжих хөрөнгө оруулалтаар 6, шинээр эхлэх 16 ажил, малын тоо толгойн албан татвараар 2 ажил хийхээр төлөвлөгдөн батлагдснаас эхний хагас жилийн байдлаар 8 ажил гэрээгээр, шууд худалдан авалтаар 3 хөтөлбөр арга хэмжээг хийж хэрэгжүүлээд байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|
| | | оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээг хэрэгжүүлэх. | | | | |
| **Зургаа. Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсийг бууруулах арга замаар ёс зүйн төлөвшлийг бий болгох.** | | | | | | |
| 6.1 | Хүүхдийн шударга байдлыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт нөлөөллийн хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь. | Жилийн турш. | Хамтарсан баг Хүүхэд гэр бүл хариуцсан нийгмийн ажилтан | Хүүхдийн зөвлөл, хамтарсан багаас сурагчдын дунд сургалт 2 удаа зохион байгуулсан.Хүүхдүүдээс судалгаа авч сургалт нөлөөллийн хөтөлбөрийг боловсруулж байна | |
| 6.2 | Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийж, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах | -Хүүхдийн шударга байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийсэн байх<br>-Нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан байх | Жилийн турш. | Хамтарсан баг Хүүхэд гэр бүл хариуцсан нийгмийн ажилтан | Хүүхдийн шударга байдалд нөлөөлж байгаа хүчин зүйлсэд дүн шинжилгээ хийж хүүхдүүдээс түүвэрчилсэн судалгаа авч багш нарын ёс зүй харилцаа хандлагын талаархи хүүхдийн гаргасан саналын дагуу хамтарсан багаас тусгайлсан арга хэмжээ зохион байгуулж 2 удаа нөлөөллийн ажлыг зохион байгуулсан. | |

ХЯНАСАН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Д.ЦЭНД-АЮУШ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ДОТООД АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Б.БАТЦЭЦЭГ